



H-2

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 184/ШШ2019/0600

Улаанбаатар хот

**Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг
биелүүлснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай**

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Л.Оюунцэцэг би

Нэхэмжлэгч: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн
хуулийн гудамж, "Ньюмайд групп" ХХК-ийн байранд байрлах "Лэндмн ББСБ" ХХК
/регистрийн дугаар: 5039754/-ийн нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 13 дугаар хороо, 8 байр
00 тоот хаягт оршин суух Онход овогт Дүүрэнгийн Аззаяа /регистрийн дугаар:
РЮ90081564/-д холбогдох,

Зээлийн төлбөрт 319 800 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг 2019 оны 02
дугаар сарын 02-ны өдөр хүлээн авч, 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдөр иргэний
хэрэг үүсгэн хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч "Лэндмн ББСБ" ХХК нь шүүхэд гаргасан нэхэмжлэлд болон
хүсэлтдээ: "Д.Аззаяа нь ...өөрийн хүсэлтийн дагуу "Лэндмн ББСБ" ХХК-тай 2017 оны
10 дугаар сарын 18-ны өдөр 29069 дугаартай цахим зээлийн эрх нээх гэрээг
байгуулсан билээ.

"Лэндмн ББСБ" ХХК нь зээлдэгч Д.Аззаяагийн LendMN аппликейшнээр
дамжуулан гаргасан хүсэлтийн дагуу 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 300 000
төгрөгийн зээлийг 10 800 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн хугацаатай, 2018 оны
05 сарын 27-нд эргэн төлөх нөхцөлтэй Д.Аззаяагийн Хаан банкны 5020777475 тоот
дансанд шилжүүлсэн.

Зээлдэгч Д.Аззаяа үндсэн зээлийн дүн болох 300 000 төгрөг, хүү 10 800
төгрөгийг төлөх үүргээ биелүүлээгүй байсан тул нийт 319 800 төгрөгийг нэхэмжилж
байсан.

Гэтэл 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зээлээ барагдуулж дууссан тул
нэхэмжлэлээс татгалзаж байна" гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

"Лэндмн ББСБ" ХХК нь Д.Аззаяад холбогдуулан 319 800 төгрөг гаргуулах тухай
нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргажээ.

Шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хүлээн авч хуульд заасан хэргийн болон
шүүхийн харьяалал зөрчөөгүй, хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлээгүй Иргэний хэрэг
шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан үндэслэл
байхгүй гэж үзэн иргэний хэрэг үүсгэсэн байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч Д.Аззаяа нь "Лэндмн ББСБ" ХХК-аас 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн биелүүлсэн болох нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбараар тогтоогдож байна.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлж, нэхэмжлэгч шаардлагаасаа татгалзсан нь гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөөгүй, хууль зөрчөөгүй байх тул хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж үзлээ.

Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж байгаа тул улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тал хувиар бууруулан тогтоож, хуульд заасан журмаар гаргуулахаар шийдвэрлэв.

Зохигч давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болохыг тус тус дурдах нь зүйтэй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75 зүйлийн 75.1-д заасныг удирдлага болгон


ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 зүйлийн 74.3-д зааснаар "Лэндмн ББСБ" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Д.Аззаяад холбогдох 319 800 төгрөг гаргуулах тухай иргэний хэрэгт хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т заасныг баримтлан улсын тэмдэгтийн хураамжид нэхэмжлэгчийн урьдчилан төлсөн 10 244 төгрөгийг улсын төсвийн орлогод үлдээж, Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн 2601025961 тоот данснаас 5 122 төгрөгийг, хариуцагчаас 5 122 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгчид олгосугай.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4-д зааснаар хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд зохигч давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүйг дурдсугай.

ШҮҮГЧ



Л.ОЮУНЦЭЦЭГ